



GROWTH FINANCE AUDIT LLC


Connect to possibility

МОНИНЖБАР ХК

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

Санхүүгийн Тайлан

(Хараат Бус Аудиторын Тайлангийн Хамт)



АГУУЛГА

ХУУДАС

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

3

АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

4

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

5

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

6

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

7-17

МОНИНЖБАР ХК

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

**КОМПАНИ БАЙГУУЛАХ
ТУХАЙ**

Монинжбар ХК нь хувьцаа эзэмшигдийн 1995 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 01 тоот шийдвэрээр үүсгэн байгуулагдаж, Улсын бүртгэлийн албанд бүртгүүлсэнээр 2061287 тоот регистр бүхий 9010001062 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээ авсан баайна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Б.Нарантуяа
Б.Цогтгэрэл
Ц.Чингүүнболд
Ц.Оргилболд
Би Ди Сек ҮЦК ХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.Нарантуяа

АЛБАН ЁСНЫ ХАЯГ

Монгол Улс, Улаанбаатар, Чингэлтэй,
6-р хороо, Бага тойруу, Өөрийн байранд

АУДИТОР

Гроут Финанс Аудит ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол
дүүрэг, 2 дугаар хороо, Эрхи цогцолбор,
603 тоот

2026.04.27. № АГ-26-64

Хараат Бус Аудиторын Тайлан

Бид Монинжбар ХК (цаашид “Компани” гэх)-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд ба бусад тайлбар мэдээллүүдийг агуулсан тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, энэхүү санхүүгийн тайлан нь Компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд (цаашид “СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд” гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн *Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага* хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (Хараат Бус Байдлын Олон Улсын Стандарт үүнд хамаарна) (цаашид “НБЕЗОУСЗ-ийн Ёс зүйн Дүрэм” гэх) болон санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Монгол Улс дахь ёс зүйн зохих шаардлагуудын дагуу Компаниас хараат бус байж, НБЕЗОУСЗ-ийн Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Эгтгээдүүдийн Санхүүгийн Тайланд Хүлээх Үүрэг Хариуцлага

Санхүүгийн тайланг СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Алдаа, зальт ажиллагааны улмаас материаллагаар буруу илэрхийлэгдээгүй санхүүгийн тайланг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх үүрэг хариуцлагыг мөн удирдлага хүлээнэ.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлагын зүгээс Компанийн тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх чадамжийг үнэлэн, шаардлагатай гэж үзвэл тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайланд тодруулж, Компанийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүргийг Компанийн удирдлага хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий эгтгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хүлээнэ.

Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага


Санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоог олж авах, бидний дүгнэлтийг агуулж буй аудиторын тайланг танилцуулах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт хэдий ч АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь бүхий л материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсч болох ба дангаараа эсвэл

нийтдээ уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах мэдээлэл хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр хүлээгдэж байвал материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу аудит хийх үед мэргэжлийн үнэлэмж гаргах, мэргэжлийн үл итгэх үзлээр хандахыг аудитын ажлын явцад шаарддаг. Бид мөн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах зэрэг явдлуудыг агуулсан байдаг тул залилангаас үүсэх материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдааны улмаас үүсэх буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горимыг боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үндэслэл болон холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн бид олж авсан нотолгоондоо тулгуурлан Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа эрхлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл бид аудиторын тайланд санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл энэхүү тодруулга нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Бид дүгнэлтээ аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд үндэслэн гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь Компанийг тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц болон агуулгыг тодруулгуудын хамт үнэлж, санхүүгийн тайлан нь холбогдох ажил гүйлгээнүүд болон үйл явдлуудыг үнэн зөв илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.



Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүйг анхаарна уу.

Монинжбар ХК
2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тодруулга	2024 мян.төг	2025 мян.төг
ХӨРӨНГӨ			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3	493.8	1,334.5
Дансны авлага	4	100,070.6	47,883.1
Татвар, НДШ-ийн авлага	5	-	33,471.7
Бусад авлага		1,500.0	1,500.0
Бараа материал	6	1,577,833.6	1,577,833.6
Урьдчилж төлсөн зардал тооцоо		178,380.6	178,380.6
Үндсэн хөрөнгө	7	404,824.8	404,824.8
Биет бус хөрөнгө		1,069.0	1,069.0
НИЙТ ХӨРӨНГӨ		2,264,172.4	2,246,297.3
ӨР ТӨЛБӨР			
Дансны өглөг	8	1,348,912.9	1,408,944.1
Цалингийн өглөг		11,645.5	11,645.6
Татварын өглөг	9	25,594.2	6,108.6
НДШ-ийн өглөг		797.5	708.1
Хүүний өглөг		29,892.3	29,892.3
Урьдчилж орсон орлого		43,943.2	43,943.2
Бусад богино хугацаат өр төлбөр		207,717.8	180,267.3
НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,668,503.4	1,681,509.2
ЭЗДИЙН ӨМЧ			
Хувьцаат		1,586,923.3	1,586,923.3
Хуримтлагдсан ашиг		(991,254.3)	(1,022,135.2)
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ		595,669.0	564,788.1
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		2,264,172.4	2,246,297.3

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



	Тодруулга	2024 мян.төг	2025 мян.төг
Борлуулалтын орлого	10	1,178,995.6	164,545.4
Борлуулалтын өртөг	11	1,114,691.7	69,282.6
Нийт ашиг		64,303.9	95,262.8
Ерөнхий ба удирдлагын зардал	12	-	126,143.7
Татварын төлөхийн өмнөх ашиг		64,303.9	(30,880.9)
Орлогын татварын зардал		6,430.4	-
Цэвэр ашиг (алдагдал)		57,873.5	(30,880.9)

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт эздийн өмч
	мян.төг	мян.төг	мян.төг
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,586,923.3	(1,049,127.8)	537,795.5
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг	-	57,873.5	57,873.5
Зарласан ногдол ашиг	-	-	-
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,586,923.3	(991,254.3)	595,669.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг	-	(30,880.9)	(30,880.9)
Зарласан ногдол ашиг	-	-	-
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,586,923.3	(1,022,135.2)	564,788.1

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

	2024 мян.төг	2025 мян.төг
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,497,596.6	233,187.5
Ажиллагчдад төлсөн	54,079.4	24,094.3
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	9,876.5	9,771.7
Бараа материал худалдан авахад төлсөн	484,137.4	38,541.7
Ашиглалтын зардалд төлсөн	10,692.6	8,629.8
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	103,198.9	13,281.3
Хүүний төлбөрт төлсөн	12,292.2	15,360.0
Татварын байгууллагад төлсөн	13,383.8	92,400.1
Даатгалын төлбөрт төлсөн	1,760.0	-
Бусад мөнгөн зарлага	242,236.5	56,299.1
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	565,939.3	(25,190.5)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	34,000.0
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	(34,000.0)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	364,244.2	128,031.2
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	609,581.1	68,000.0
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	321,780.8	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(567,117.7)	60,031.2
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(1,178.4)	840.7
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	1,672.2	493.8
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	493.8	1,334.5

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МОНИНЖБАР ХК
2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

1. Ерөнхий мэдээлэл

Монинжбар ХК нь 2007 оны 9 дүгээр сард

-Барилгын дотор халаалт салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний угсралт, дулааны гол шугам сүлжээний угсралт, ус хангамж ариутгах татуургын шугам сүлжээний угсралт, барилгын дотор гэрэлтүүлэг цахилгаан хангамжийн угсралт,

-Хатуу болон хайрган хучилттай зам барих, зам талбайн тохижилт хийх,

-Гадаад худалдаа,

-Төмөр битон эдлэлийн үйлдвэрлэл,

-Авто граж, ил зогсоол ажиллуулах ажил эрхлэхээр үүсгэн байгуулагдсан.

Компанийн хувьцааны мэдээлэл

Хувьцаа эзэмшигч	Эзэмшиж буй хувь	Хувьцааны тоо
Б.Нарантуяа	26.98	4,281,519
Б.Цогтгэрэл	22.36	3,548,360
Ц.Чингүүнболд	11.49	1,823,375
Би Ди Сек УЦХ ХХК	6.35	1,007,696
Ц.Оргилболд	5.75	912,481
Бусад	27.07	4,295,801
Нийт дүн	100.0	15,869,233

2. Санхүүгийн тайлагналын зарчим

(а) Тайлагналын нийцэл

Энэхүү санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид “СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд” гэх)-ын дагуу бэлтгэсэн. Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд болон тайлант жилд гарсан өөрчлөлтийг Тодруулга 3-т харуулсан болно.

(б) Үнэлгээний суурь

Санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчимд үндэслэн бэлтгэсэн.

(в) Тасралтгүй үйл ажиллагааны зарчим

Санхүүгийн тайланг удирдлага зохистой гэж үзсэний дагуу тасралтгүй үйл ажиллагаа явуулна гэсэн зарчим дээр тулгуурлан бэлтгэсэн.

(г) Үйл ажиллагааны болон толилуулгын валют

Энэхүү санхүүгийн тайланг Компанийн бүртгэлийн валют болох Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр толилуулсан бөгөөд энэ нь Компанийн үйл ажиллагаа явуулж буй гол эдийн засгийн орчны үндсэн валют болно.

(д) Таамаглал, тооцоолол болон үнэлэмжийн хэрэглээ

Санхүүгийн тайланг СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудад нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал, тооцоолол болон үнэлгээ хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлгээ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт болон бүртгэсэн хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын дүнг тодорхойлоход нөлөөлдөг. Бодит үр дүн нь эдгээр таамаглал, тооцоололоос ялгаатай байж болно.

Удирдлага эдгээр тооцоолол болон түүнд хэрэглэсэн таамаглалыг байнга хянаж байдаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд аливаа өөрчлөлт гарсан тохиолдолд тухайн өөрчлөлт гарсан тайлант жил болон ирээдүйн тайлант жилүүдэд уг тооцооллын өөрчлөлтийг хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн тайланд мэдэгдэхүйц нөлөө бүхий нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд хэрэглэгдсэн таамаглал, тооцоолол, үнэлэмжийн талаарх мэдээлэл болон дараагийн тайлант үед хамаарах материаллаг залруулгын нөлөө бүхий эрсдэлийн үндэслэл болон тооцооллын талаарх мэдээллийг доорх тодруулгад тусгасан:

Тодруулга 3 (ж) – Үндсэн хөрөнгийн ашиглалтын жил, Тодруулга 3(и) - Биет бус хөрөнгө ашиглах жил



3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд

Компани 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Тодруулга (НББОУС 1 болон СТОУС Практик Мэдэгдэл 2-ын нэмэлт өөрчлөлт)-ын шаардлагыг мөрдсөн. Хэдийгээр нэмэлт өөрчлөлтүүд нь Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод аливаа өөрчлөлтийг оруулаагүй боловч уг нэмэлт өөрчлөлтүүд нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэлд нөлөөлж, санхүүгийн тайланд тодруулагдсан.

Нэмэлт өөрчлөлтүүд нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын “үндсэн” гэх ухагдахууныг халж, нягтлан бодох бүртгэлийн “материаллаг” бодлогуудыг тодруулахыг шаардсан. Нэмэлт өөрчлөлтүүд нь мөн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодруулахад материаллаг байдлыг хэрхэн мөрдөх талаарх удирдамжийг агуулсан. Мөн уг нэмэлт өөрчлөлтүүд нь санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдийг санхүүгийн тайлангийн бусад мэдээллийг ойлгоход нь туслахуйц хэрэгцээтэй, тухайн байгууллагын онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаарх мэдээллээр хангахад нь тухайн байгууллагад туслахад чиглэсэн.

Компани нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн дараах материаллаг бодлогуудыг баримталсан ба тусгайлсан хэсэгт онцлон зааснаас бусдаар эдгээр нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь тайланд тусгагдсан бүх жилүүдэд тогтвортойгоор хэрэглэгдсэн болно.

(а) Орлого болон хөрөнгийн албан татвар

Компани нь Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу өөрийн болон бусад олгосон орлого ба хөрөнгөд доорхи төрлийн татварыг ногдуулж төлөх ёстой.

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
- Нэмэгдсэн өртгийн албан татвар
- Хувь хүний орлогын албан татвар
- Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
- Улсын тэмдэгтийн хураамж
- Газрын төлбөр

(б) Харилцагчтай байгуулсан гэрээний орлого

Компанийн ажилчдад болон түр гэрээт ажилчдад олгосон хөдөлмөрийн хөлс, хувь хүнээс худалдаж авсан бараа, гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт Монгол Улсын “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай”, “Хувь хүний орлогын албан татварын тухай” хуулийн дагуу дундын суутгал хийж, төсөвт төлнө.

Орлого нь компанийн ердийн үйл ажиллагааны явцад тайлант хугацаанд бий болсон бөгөөд өмч эзэмшигчдээс оруулсан хөрөнгөөс бусад шалтгаанаар өмчийн өсөлт хэлбэрээр илэрсэн, эдийн засгийн өгөөжийн дотогш урсгал юм. Орлого нь үйл ажиллагааны орлого болон бусад орлого, олзыг багтаана. Үйл ажиллагааны орлогод үзүүлсэн үйлчилгээ, бараа борлуулалтын орлого орох бөгөөд бусад орлого ба олзод түрээс, хүү, ноогдол ашиг, эрхийн шимтгэл, урамшууллын орлого болон бусад орлогууд хамрагдана.

(в) Дансны болон бусад авлага

Авлагад өнгөрсөн хугацааны үйл ажиллагааны үр дүнд зээл тооцооны үндсэн дээр үүссэн, нэхэмжлэхийн үүрэг хангагдамагц мөнгө болж хувирах зүйлс багтана. Үүнд зээлээр борлуулсан бараа, ажил үйлчилгээний авлага, ажилчидтай хийх тооцоогоор үүсэн авлага, аливаа татварын илүү төлөлт, ноогдол ашгийн авлага, хүүгийн авлага зэргийг хамруулна. Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа, урьдчилж гарсан зардлууд нь хожим мөнгө бус бараа материал, дуусаагүй үйлдвэрлэл зэрэг холбогдох хөрөнгө болж хувирдаг тул эдгээрийг авлага гэж үзэхгүй.

Авлагыг найдвартай хэмжиж болохуйц бөгөөд компани нэхэмжлэх баримт үйлдэн худалдан авагч буюу хариуцагч талд шилжүүлснээр мөнгө буюу бусад хөрөнгө хүлээн авах эрхтэй болсон нөхцөлд балансдаа хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр үнэлж, тайлагнана. Цэвэр боломжит үнэ цэнэ нь нэхэмжилсэн дүнгээс авлагыг цуглуулахтай холбогдон гарах аливаа тооцоолсон зардлыг хассан дүн юм. Өөрөөр хэлбэл авлагын нэрлэсэн үнээс найдваргүй авлагын нөөцийг хассан цэвэр дүнгээр илэрхийлнэ. Холбоотой этгээдтэй үүссэн авлагын тооцоог үүссэн тухай бүр бүртгэнэ.



3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, үргэжлэл

Холбоотой этгээдээс авах авлагыг дараахь туслах дансаар ангилан хөтөлнө.

- Удирдах албан тушаалтнаас авах авлага
- Бусад холбоотой талаас авах авлага

(г) Татвар

Орлогын татварын зардал нь тайлант үеийн болон хойшлогдсон татварын зардлаас бүрддэг. Тайлант үеийн татвар болон хойшлогдсон татварыг эздийн өмч эсвэл бусад дэлгэрэнгүй орлогоор шууд хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

i. Тайлант үеийн татвар

Тайлант үеийн татвар гэдэг нь өмнөх жилүүдийн татварын өрийн тохируулга болон тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан эсвэл мөрдөгдөж байгаа татварын хувь хэмжээг ашиглан тухайн жилийн татвар ногдох ашиг, татварын алдагдалд суурилан хүлээгдэж буй татварын өр эсвэл авлага юм.

ii. Хойшлогдсон орлогын татвар

Хойшлогдсон татварыг санхүүгийн тайлангийн зорилгоорх хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татварын зорилгоор ашиглагдах дүн хоёрын хоорондох түр зөрүүн дээр үндэслэн хүлээн зөвшөөрдөг.

Тайлант үеийн эцсээр хүчин төгөлдөр болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөж байгаа татварын хувь хэмжээнд үндэслэн хөрөнгө нь хэрэгжих буюу өр төлбөрийг төлөх тайлант үед мөрдөгдөхөөр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хойшлогдсон татварыг хэмждэг.

Компани тайлант жилийн болон хойшлогдсон татварын дүнг тодорхойлохдоо татвартай холбоотой тодорхойгүй нөхцөл байдал, нэмэлт татвар болон хүү төлөгдөх магадлал гэх мэт хүчин зүйлсийн нөлөөг тооцож үздэг.

Компани хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн цэвэр дүнг гаргах хууль ёсны хүчин төгөлдөр эрхтэй бөгөөд түүнд ногдуулсан татварыг тухайн компанийг хариуцсан татварын байгууллагаас ногдуулсан тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг цэвэр дүнгээр тайлагнаж болно. Ашиглагдаагүй татварын алдагдал, хөнгөлөлт болон татвар ногдох орлогоос хасагдах түр зөрүүг тэдгээрийг ашиглаж болохуйц хэмжээний ирээдүйн татвар ногдох орлого олох нь магадлалтай хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгөөр хүлээн зөвшөөрдөг. Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант жилийн эцэс бүрт дахин хянаж үздэг. Хойшлогдсон татварын хөрөнгийн өгөөжийг ашиглах боломжтой хангалттай хэмжээний татвар ногдох ашиг олох магадлал байхгүй бол тэр хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг бууруулдаг.

i. Нэмэгдсэн өртгийн албан татвар

Борлуултын орлого, зардал болон хөрөнгийг дараахаас бусад тохиолдолд нэмэгдсэн өртгийн албан татвар

("НӨАТ") ороогүй цэвэр дүнгээр хүлээн зөвшөөрдөг:

- Хөрөнгө худалдан авах эсвэл үйлчилгээ авахад гарсан НӨАТ-ыг татварын байгууллагаас нөхөн авах боломжгүй тохиолдолд тухайн НӨАТ-ыг хөрөнгийг худалдан авах зардлын нэг хэсэг буюу зардлын зүйлийн нэг хэсэг гэж хүлээн зөвшөөрдөг;
- Авлага ба өглөгийг бүртгэхдээ НӨАТ-ын дүнг хамтад нь оруулах.

Татварын байгууллагаас авах эсвэл төлөх НӨАТ-ын цэвэр дүнг санхүүгийн байдлын тайланд авлага эсвэл өглөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.



3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, үргэлжлэл

(д) Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрөх бөгөөд анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үндсэн хөрөнгийн дансны үнэ нь түүний өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн байдаг. Үндсэн хөрөнгийн өртөгт тухайн хөрөнгийг худалдан авах болон барьж байгуулахтай шууд холбогдон гарсан зардал, мөн удирдлагын зорилгоор үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож түүнийг байршуулах болон шаардлагатай нөхцөлийг хангахтай холбоотой гарсан бусад зардлууд, мөн тухайн хөрөнгийг задлах, зайлуулах болон байрлаж байсан талбайг нь сэргээн засварлахад гарах зардлуудыг хамааруулна.

Үндсэн хөрөнгийн томоохон хэсгүүд нь ашиглалтын өөр өөр хугацаатай бол тэдгээрийг үндсэн хөрөнгө (үндсэн бүрэлдэхүүн хэсэг) гэж тусад нь бүртгэнэ.

Дараа үеийн зардлыг үндсэн хөрөнгийн дансны үнэд оруулан бүртгэх буюу зөвхөн эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг хүртэх магадлалтай бөгөөд өртгийг найдвартай хэмжих боломжтой гэдэг нь тогтоогдсон үед капиталжуулан бүртгэдэг. Үндсэн хөрөнгийн шинэчлэн сольсон хэсгүүдийн үлдэгдэл өртгийг данснаас хасна. Урсгал засварын зардлыг гарсан тухайн тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрдөг.

Үндсэн хөрөнгийн зүйлсийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн ашиглалтын жилээр тооцон шулуун шугамын аргаар элэгдүүлж, ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг.

Одоогийн болон харьцуулсан хугацаанд тооцоолсон ашиглалтын хугацаа дараах байдалтай байна:

	Ашиглагдах хугацаа
Машин, тоног төхөөрөмж	10 жил
Тавилга, эд хогшил	10 жил
Тээврийн хэрэгсэл	10 жил
Компьютер	2 жил

Үндсэн хөрөнгийн зүйлсийг борлуулснаас үүссэн олз, гарзыг үндсэн хөрөнгийн дансны үнэ болон цэвэр борлуулалтын орлогын зөрүүгээр тодорхойлдог.

Хөрөнгийн элэгдэл байгуулах арга, ашиглахаар тооцсон хугацаа болон үлдэх өртгийг тайлант жил бүрийн эцэст дахин хянаж, шаардлагатай тохиолдолд тохируулга хийдэг. Энэхүү өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзэн бүртгэлд тусгана.

(е) Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан хорогдуулга болон үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр бүртгэдэг.

Биет бус хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх тохиолдолд холбогдон гарсан аливаа дараа үеийн зардлыг капиталжуулна. Бусад гарсан зардлуудыг гарсан тухай бүрд нь ашиг, алдагдлаар бүртгэдэг.

Биет бус хөрөнгийн хорогдуулгыг тэдгээрийг ашиглах боломжтой болсон өдрөөс нь эхлэн тооцсон ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцдог.

Компанийн биет бус хөрөнгө нь нягтлан бодох бүртгэлийн програм хангамж ба зохиогчийн эрхээс бүрдэх бөгөөд анх өртгөөр нь хүлээн зөвшөөрсөн.

	Ашиглагдах хугацаа
Программ хангамж	3 жил

Биет бус хөрөнгийн хорогдуулгын зардлыг ашиг алдагдлын тайлан дахь “ерөнхий болон удирдлагын зардал” хэсэгт тусгасан.

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, үргэлжлэл

Тодорхой хугацаанд ашиглагдах биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа болон хорогдуулах аргыг тайлант үе бүрийн эцэст хянаж үздэг. Тодорхойгүй хугацаанд ашиглагдах биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг тайлант үе бүрийн эцэст хянаж үзэн, тодорхойгүй хугацаанд ашиглахад хүргэж буй үйл явдал болон нөхцөл байдал хэвээр байгааг үнэлдэг. Өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт хэсэгт тусгадаг.

(ё) Бараа материал

Бараа материалыг өртөг болон цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар үнэлдэг. Бараа материалын өртгийг дундаж өртгийн аргаар тодорхойлох бөгөөд бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, үйлдвэрлэлийн болон хөрвүүлэлтийн зардал болон одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авч ирэхтэй холбоотой гарсан бусад зардлууд ордог (үйлдвэрлэл, угсралт ба тээврийн зардал гэх мэт).

Өртөг гэдэг нь үр өгөөжийг бий болгохын тулд зарцуулсан солилцооны үнэ буюу гарз юм.

Өртгийн төв гэдэг нь бүтээгдэхүүн үйлчилгээний өртгийг тодорхойлохын тулд зардлыг хуримтлуулан бүртгэж байгаа объект юм. Өөрөөр хэлбэл, өртгийн төв гэж аливаа нэгж, үйл явдал, үйл ажиллагаа бөгөөд энэ нь бүтээгдэхүүн, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, төсөл, гэрээ, процесс, байгууллагын газар, хэлтэс, тасаг, байрлал буюу байгууллагын салбар гэх мэт байж болно.

Цэвэр боломжит үнэ цэнэ гэдэг нь бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад борлуулахаар тооцсон үнээс түүнийг иж бүрдэл болгохоор тооцсон зардал ба борлуулахад шаардагдах зардлыг хассан дүнг хэлнэ.

(ж) Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Санхүүгийн байдлын тайланд тусгасан мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд бэлэн мөнгө ба банкинд байгаа мөнгө орно. Мөнгөн гүйлгээний тайланд зориулж, дээр дурдсан бэлэн мөнгө ба банкинд байгаа мөнгийг цэвэр дүнгээр нь буюу банкинд төлөх богино хугацаат өр төлбөр ороогүй дүнгээр тусгасан.

(з) Санхүүгийн бус хөрөнгө – үнэ цэнийн бууралт

Бараа материал болон хойшлогдсон татварын хөрөнгөөс бусад Компанийн санхүүгийн бус хөрөнгүүдийн дансны үнэд хөрөнгийн үнэ цэнэ буурч болзошгүй болохыг илтгэх шинж тэмдэг байгаа эсхийг тайлант үе бүрийн эцэст үнэлдэг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрвэл хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолдог. Ашиглалтын хугацааг нь тодорхойлох боломжгүй эсвэл одоогоор ашиглагдах боломжгүй гүүдвилл болон биет бус хөрөнгийн нөхөгдөх дүнг жил бүрийн ижил үед шалгадаг.

(н) Хувьцаат капитал

Энгийн хувьцаа нь эздийн өмчийн хэсэгт ангилагддаг. Энгийн хувьцаа болон хувьцааны опцион гаргахад шууд холбогдон гарах нэмэлт зардлыг аливаа татварын дараах цэвэр дүнгээр өмчийн хэсгийг бууруулах байдлаар хүлээн зөвшөөрдөг.

Энгийн хувьцааны ногдол ашгийг санхүүгийн тайланг бэлтгэж дуусахаас өмнө төлөөлөн удирдах зөвлөл батлавал, тусад нь эздийн өмч хэсэгт нөөцөөр хүлээн зөвшөөрнө. Энгийн хувьцааны ногдол ашгийг өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч, Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлах үед эздийн өмчөөс хасдаг.

(к) Болзошгүй зүйлс

Болзошгүй өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөггүй. Эдийн засгийн өгөөжийн гадагш урсгал гарах магадлал маш бага биш л бол болзошгүй өр төлбөрөөр тайланд тодруулна. Болзошгүй хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөггүй. Эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн дотогш урсгал орох магадлалтай бол санхүүгийн байдлын тайланд тодруулна.

(л) Дансны ба бусад өглөг

Дансны ба бусад өглөгийг анх хүлээн авсан дүнтэй харгалзах бодит үнэ цэнээр бүртгэх ба түүнээс хойш хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Холбоотой этгээдэд өгөх өглөгийг дараахь дансаар ангилан хөтөлнө.

- Хувьцаа эзэмшигчид өгөх өглөг
- Удирдах албан тушаалтанд өгөх өглөг
- Бусад холбоотой талд өгөх өглөг

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, үргэлжлэл

(м) Нөөц ба болзошгүй өр төлбөр

Компани өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн хуулиар хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, уг үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөц шаардлагатай гэдэг нь тодорхой болсон ба үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой болсон үед нөөцийг хүлээн зөвшөөрдөг. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ нь материаллаг нөлөөтөй бол нөөцийн дүнг ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр тооцоолдог.

Эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн гадагш урсгал гарах магадлалгүй буюу түүний дүн нь найдвартай тооцоологдох боломжгүй, эдийн засгийн өгөөжийн гадагш урсгал гарах магадлал маш бага бол болзошгүй өр төлбөрөөр тайланд тодруулна. Эдийн засгийн өгөөжийн гадагш урсгал гарах магадлал маш бага байхаас бусад тохиолдолд нэг буюу хэд хэдэн ирээдүйн үйл явдал эсвэл үйл явдал тохиолдоогүй үед болзошгүй өр төлбөрийг байгаа эсэхийг тодорхойлох боломжтой үүргийг мөн болзошгүй өр төлбөр гэж тодруулна.

(н) Холбоотой талууд

i. *Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд компанитай холбоотой гэж үзнэ:*

- Компанийг хянадаг эсвэл хамтран хянадаг;
- Компанид мэдэгдэхүйц нөлөөлөлтэй;
- Компанийн эсвэл түүний толгой компанийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.

ii. *Дараах нөхцөлүүдийн аль нэг нь хангагдаж байвал тухайн аж ахуйн нэгж компанитай холбоотой гэж үзнэ:*

- Тухайн аж ахуйн нэгж болон компани нь нэг группийн бүрэлдэхүүнд багтаж байвал (өөрөөр хэлбэл, толгой компани, охин компани болон нэг толгой компанид хамаардаг охин компаниуд бүгд бусадтайгаа холбоотой);
- Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат компани эсвэл хамтын хяналттай компани бол (эсвэл нөгөө аж ахуйн нэгжийг багтаасан группийн нэг аж ахуйн нэгжийнх нь хараат эсвэл хамтын хяналттай компани бол);
- Хоёр аж ахуйн нэгж хоёулаа гуравдагч талын хамтын хяналттай компани бол;
- Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч талын хамтын хяналттай компани ба харин нөгөө аж ахуйн нэгж нь уг гуравдагч талын хараат компани бол;
- Тухайн аж ахуйн нэгж нь компани эсвэл түүнтэй холбоотой аж ахуйн нэгжийн аль нэгнийх нь ажилчдын тэтгэвэр тэтгэмжид зориулсан ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн төлөвлөгөө бол;
- (i)-д тодорхойлсон хувь хүн тухайн аж ахуйн нэгжид хяналт тавьдаг эсвэл хамтран хянадаг бол;
- (i)-д тодорхойлсон хувь хүн тухайн аж ахуйн нэгжид мэдэгдэхүйц нөлөөтэй эсвэл уг аж ахуйн нэгж (эсвэл түүний толгой компани)-ийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.
- Компани эсвэл компанийн толгой компанид менежментийн үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж эсвэл группийн гишүүн аж ахуйн нэгж бол.

Хувь хүний гэр бүлийн ойр дотны гишүүд гэдэг нь компанитай ажил хэргийн харилцаанд орох явцад хувь хүнд нөлөөлөх эсвэл түүний нөлөөнд автаж болзошгүй гэр бүлийн гишүүд юм.

(о) Санхүүгийн орлого

Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн ("ҮАХ") аргыг ашиглан бүртгэдэг. ҮАХ нь тооцоолсон ирээдүйн мөнгөн төлбөр, орлогыг санхүүгийн хэрэглүүрийн ашиглалтын хугацаанд эсвэл түүнээс богино хугацаанд санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн дансны цэвэр дүн хүртэл бууруулдаг хүү юм. Хүүгийн орлогыг ашиг, алдагдлын орлогын тайланд бүртгэнэ.

4. Тайлант жилд хэрэгжиж эхэлсэн СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудад орсон шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд

Компани нь НББОУСЗ-өөс гаргасан 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийг тайлант жилд хэрэгжүүлсэн.

Хэрэгжих огноо	Шинэ стандарт эсвэл нэмэлт өөрчлөлт
2024 оны 01 дүгээр сарын 01	- СТОУС 17 Даатгалын гэрээ - НББОУС 1 ба СТОУС Практик Мэдэгдлийн 2-т оруулсан нэмэлт өөрчлөлтүүд - Нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулга - НББОУС 8-ын нэмэлт өөрчлөлт - Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын тодорхойлолт - НББОУС 12-ын нэмэлт өөрчлөлт - Дан ганц ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгө, өр төлбөрт хамаарах хойшлогдсон татвар - СТОУС 17 болон СТОУС 9-ийн анхны хэрэгжүүлэлт - Харьцуулагдах мэдээлэл (СТОУС 17-ийн нэмэлт өөрчлөлт)
2024 оны 5 дугаар сарын 23	Олон Улсын татварын шинэчлэл – Хоёр баганат моделийн зарчим – НББОУС 12-ын нэмэлт өөрчлөлт

СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд нь тайлант жилд Компанийн санхүүгийн байдал болон гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн тодруулгуудад материаллаг нөлөө үзүүлээгүй болно.

5. Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудад орсон шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд

Компанийн санхүүгийн тайланг батлан гаргах үед батлагдсан байсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийг дор тодруулсан болно. Компани эдгээрийг хэрэгжиж эхлэхээр хүлээгдэж буй үеэс дагаж мөрдөнө.

Компани нь санхүүгийн тайланд эдгээр шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд томоохон нөлөө үзүүлэхгүй гэсэн хүлээлттэй байна.

Хэрэгжих огноо	Шинэ стандарт эсвэл нэмэлт өөрчлөлт
2025 оны 01 дүгээр сарын 01	НББОУС 21-ийн нэмэлт өөрчлөлт – Арилжигдах боломжгүй байх
Сонголттойгоор мөрдөх боломжтой / мөрдөх хугацааг тодорхойгүйгээр хойшлуулсан	СТОУС 10 болон НББОУС 28-ын нэмэлт өөрчлөлт - Хөрөнгө оруулагч болон хараат эсвэл хамтарсан компанийн хөрөнгийн борлуулалт эсвэл худалдах үнэ

Монинжбар ХК
 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

3. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Ангилал	(мян.төг)	
	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
КАСС ДАХЬ МӨНГӨ		
Бэлэн мөнгө	240.7	240.7
БАНКИН ДАХЬ МӨНГӨ		
Харилцах данс	253.1	1,093.8
Нийт дүн	<u>493.8</u>	<u>1,334.5</u>

4. ДАНСНЫ АВЛАГА

Ангилал	(мян.төг)	
	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
Эхний үлдэгдэл	120,070.6	100,070.6
Нэмэгдсэн	-	9,900.0
Хасагдсан	20,000.0	62,087.5
Нийт дүн	<u>100,070.6</u>	<u>47,883.1</u>

5. ТАТВАРЫН АВЛАГА

Ангилал	(мян.төг)	
	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын	-	33,471.7
Нийт дүн	<u>-</u>	<u>33,471.7</u>

Монинжбар ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

6. БАРАА МАТЕРИАЛ

Ангилал	Дуусаагүй үйлдвэрлэл	Бэлэн бүтээгдэхүүн	Бараа	Хангамжийн материал	(мян.төг) Нийт дүн
2025 оны 1 сарын 1 Нэмэгдсэн	1,528,732.3	800.0	9,743.1	38,558.2	1,577,833.6
2025 оны 12 сарын 31	1,528,732.3	800.0	9,743.1	38,558.2	1,577,833.6

7. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Ангилал	Барилга байгууламж	Машин, тоног техөөрөмж	Тавилга эд хогшил	Компьютер, бусад хэрэгсэл	(мян.төг) Нийт дүн
Анхны өртөг					
2025 оны 1 сарын 1	416,760.0	135,000.0	10,303.9	14,983.9	577,047.8
Нэмэгдсэн	-	-	-	-	-
2025 оны 12 сарын 31	416,760.0	135,000.0	10,303.9	14,983.9	577,047.8
Хуримтлагдсан элэгдэл					
2025 оны 1 сарын 1	14,717.1	134,519.3	9,529.1	13,457.5	172,223.0
Тайлант онд байгуулсан элэгдэл	-	-	-	-	-
2025 оны 12 сарын 31	14,717.1	134,519.3	9,529.1	13,457.5	172,223.0
Дансны үнэ	402,042.9	480.7	774.8	1,526.4	404,824.8

Монинжбар ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

8. ДАНСНЫ ӨГЛӨГ

	(мян.төг)	
Ангилал	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
Төлөгдөх хугацаандаа байгаа	1,348,912.9	1,408,944.1
Нийт дүн	<u>1,348,912.9</u>	<u>1,408,944.1</u>

9. ТАТВАРЫН ӨР

	(мян.төг)	
Ангилал	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын	6,430.4	-
Нэмэгдсэн өртгийн албан татварын	17,543.5	5,619.6
Хувь хүний орлогын албан татварын	1,620.3	489.0
Нийт дүн	<u>25,594.2</u>	<u>6,108.6</u>

10. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

	(мян.төг)	
Ангилал	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
Бараа борлуулсны орлого	1,178,995.6	164,545.4
Нийт дүн	<u>1,178,995.6</u>	<u>164,545.4</u>

11. БОРЛУУЛАЛТЫН ӨРТӨГ

	(мян.төг)	
Ангилал	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,114,691.7	69,282.6
Нийт дүн	<u>1,114,691.7</u>	<u>69,282.6</u>

Монинжбар ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

12. ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

Ангилал	(мян.төг)	
	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
Ажиллагчдын цалин	-	30,732.0
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн	-	5,449.3
Албан татвар, төлбөр, хураамжийн	-	2,291.9
Бичиг хэрэг	-	1,251.4
Шуудан холбоо	-	1,540.7
Мэргэжлийн үйлчилгээ	-	19,004.9
Ашиглалтын зардал	-	7,845.3
Засварын зардал	-	12,298.2
Түрээсийн зардал	-	14,919.9
Шатахууны зардал	-	12,073.9
Хүлээн авалтын зардал	-	766.8
Хөдөлмөр аюулгүй байдлын зардал	-	2,500.0
Бусад зардал	-	15,469.4
Нийт дүн	-	<u>126,143.7</u>

13. ХОЛБООТОЙ ТАЛУУДАЙ ХИЙСЭН ГҮЙЛГЭЭ

Тайлант хугацаанд холбоотой талуудтай гүйлгээ хийсэн ба эдгээр нь санхүүгийн тайланд тусгагдсан, зохих тодруулга хийгдсэн.

14. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

Тус компанид 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар болзошгүй өр төлбөр байхгүй байна.

15. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВЦ

Компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан гарснаас хойш санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхүйц үйл явдал гараагүй байна.